

АНГЛИ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН ШАЛГАЛТЫН СЭДВИЙН ХҮРЭЭНД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

ГАДААД ХЭЛНИЙ БОЛОВСРОЛ, СУРГУУЛИЙН МЕНЕЖМЕНТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Т.САРАННЭМЭХ

Уралдаант шалгалтад англи хэлний хичээлээр 3391 сурагч хамрагдаж анхны онооны дундаж 54,7, хэмжээст онооны дундаж 539.5, проценталь онооны дундаж 62.97 %-тай шалгагджээ.

Англи хэлний шалгалтын А вариантын даалгаврын бүхэлд нь харж үзэхэд:

Даалгаврын бүтэц:

- I. Grammar section
- II. Vocabulary section
- III. Communication section
- IV. Reading section гэсэн бүтэцтэй боловсруулагдсан. Даалгавар бүрийг задалж үзвэл дараахь агуулгыг багтаасан байна.

Grammar section:

1. Хамаатуулах тэмдэг нэр (possessive adjectives)
2. Жирийн одоо / одоо үргэлжилж байгаа цагууд (present simple versus present continuous)
3. Тодорхой ялгац гишүүн (definite article)
4. Жирийн өнгөрсөн / өнгөрсөнд үргэлжилж байсан цагууд (past simple versus past continuous)
5. Үйлт нэр (participles)
6. Холбоос (linking words)
7. Угтвар үг (prepositions)
8. Угтвар үг (prepositions)
9. Одоо төгс үргэлжилж байгаа цаг (present perfect continuous)
10. Холбох төлөөний үг (relative pronoun)
11. Хэлц үйл үг (phrasal verb)
12. Болзолт өгүүлбэрийн хэлбэр 2 (conditional type 2) гэсэн хэл зүйн дүрмийн мэдлэгийг шалгасан (1-12) даалгавар

Үгсийн сан: - Англи хэлний B1 түвшинд хэрэглэгддэг ижил утгатай үг хэллэг, үгийн утга тодорхойлох зэрэг (13- 28) даалгавар оруулжээ.

Харилцан яриа: Тохирох хариултыг сонгох, өгөгдсөн асуултыг зөв сонгож өгүүлбэрийг гүйцээх зэрэг сонгох хэлбэрийн (29-36) 8 даалгавартай.

Унших чадвар: 2 эх оруулсан бөгөөд эхийг уншиж, зөв хариултыг сонгох даалгаврууд (37-46) байна.

Сурагчдын хийсэн даалгаврын item analiz –ийг харахад:

ХҮНД ХҮНДЭВТЭР ДААЛГАВАР

Хүнд хөнгөний зэрэг	Ялгаатай байдал	Хамаарал
15	6	43
10	43 reading – verb using	7
17 vocab – phrasal verb	12	12
38 reading - participle	44 reading – meaning	41
36 communication - question	7	37
6	41	44
45 reading - meaning	37	42
25	42	39
7 grammar – phrasal verbs	36	36
42 reading – word combination	39 reading – words meaning	38
41 reading - vocabulary	38	45
37 reading -vocabulary	17	17

7, 17, 36, 37, 38, 41, 42 - хүнд даалгавар / хүнд хөнгөний зэрэг, ялгаатай байдлаараа хүнд даалгавар болсон байна/

6, 12, 39, 43, 44, 45 – хүндэвтэр даалгавар / ялгаатай байдал, хамаарлаараа хүндэвтэр даалгавар болсон байна./

37, 38, 39, 41, 42, 43, 44 – reading /унших/ даалгавар 10 байгаагаас 8 нь хүнд болон хүндэвтэр даалгаварт орсон байна. Сурагчдын дийлэнх буюу 70.1% нь эдгээр даалгавруудыг хийсэн байна.

37- 81.8%, 38 – 68.3%, 39 – 82%, 41 -78.1%, 42 – 76.9%, 43 – 53.1%, 44 -50.2% нь огт хийж чадаагүй буруу хариулсан байна.

САЙЖРУУЛЖ АШИГЛАХ БОЛОМЖИТ ДААЛГАВАР


Хүнд хөнгөний зэрэг	Ялгаатай байдал	Хамаарал
9	21 vocab - matching	21
27	22	22
23 vocab - matching	31 communication - meaning	31
30 communication - meaning	23	24
19 vocab - adjective	24 vocab - matching	23
1	30	30
28	2 grammar – verb tense	13
22 vocab - matching	20 vocab - matching	20
3	13 vocab - adjective	35
32	19	2

22, 23, 30 дугаар даалгаврууд нь хүнд хөнгөний зэрэг дундаж, ялгах чадвар сайтай, сурагчдын гүйцэтгэл сайн дийлэнх сурагчид зөв хариулсан байна. Энэ даалгаврын тавил сайн, сурагчдад танил байна.

2, 13, 19, 20, 21, 24 дүгээр даалгаврууд нь ялгаатай байдал, хамаарал бүхий даалгаврууд байсан тул сурагчдын ихэнх нь зөв хариулсан байна.

22 – 54.5%, 23 -62.7%, 30 – 59.2% - буюу дунджаар 58.7% нь бүрэн зөв хариулсан.

2 - 50.5%, 13 – 42.1%, 19 – 58.8%, 20 – 47%, 21 – 47.1%, 24 – 41.9% - буюу 47.9% нь зөв бүрэн хариулсан байна. Иймээс эдгээр даалгаврууд нь сайжруулан ашиглаж болох даалгаврууд байгаа нь нийт сурагчдын 53.3% зөв хийснээс харагдаж байна.



Парабол – хонхон хэлбэрийн муруйгаар гарсан анализыг ашиглан даалгаврын гүйцэтгэлийг үнэлгээний 8 түвшингээр тооцвол:

Түвшин	Үнэлгээ, хувь	Сурагчдын тоо	Сурагчдын тоо, хувь	Тайлбар
VIII	90 – 100	34	141- 8.3%	Нийт сурагчдын 8.3% нь VII – VIII түвшинд байна.
VII	80 – 89	107		
VI	70 – 79	140	287 – 16.8%	Нийт сурагчдын

V	60 - 69	147	1276 – 74.9%	16.8% нь V - VI түвшинд байна.
IV	50 – 59	220		Нийт сурагчдын 74.9% нь I – IV түвшинд гүйцэтгэсэн байна.
III	40 - 49	274		
II	30 - 39	345		
I	0 - 29	437		

0 – 10 оноо авсан – 251 сурагч, 11 – 20 оноо авсан – 805 сурагч, 21 – 30 оноо авсан – 402 сурагч, 31 – 42 оноо авсан 246 сурагч байна.

ЗӨВЛӨМЖЛӨХ НЬ:

Нийт сурагчдын гаргасан алдааны дийлэнх нь үгсийн сан /vocabulary/, унших /reading/ даалгаврууд байсан.

Багш нар сурагчдад шинэ үгийг зааж таниулахдаа ойролцоо, эсрэг, холбоо үгээр, ижилсэх утгаар, өгүүлбэр зохиолгох гэх мэтээр тайлбарлан таниулж хэрэглээний түвшинд эзэмшүүлж чадварт сургах нь зүйтэй байна. Үүнд: Шинэ үгийг

- Ажиглаж, харьцуулах, жиших
- Задлан шинжлэх, хэрэгцээт мэдээллийн талаар нэгтгэн дүгнэх
- Хам сэдвийн хүрээнд үгийн нөөц, үгийн олон утгыг ялган таних
- Хэл зүйн мэдлэгт тулгуурлан үгийн санг баяжуулах
- Загварын дагуу энгийн болон нийлмэл өгүүлбэр зохиолгох зэргээр арга хэлбэрийг хэрэглэж болох юм.

Нийт даалгаврын 22% нь уншиж ойлгож чадварыг шалгасан даалгавар байгаа нь сурагчдын унших хурд сул, цагийн хуваарилалт дутмаг байсан байх магадлалтай. Хэдийгээр хариултауд сонгох хэлбэртэй боловч үг хэллэг танил бус, шинэ үг ихтэй байсан нь харагдаж байна. Нийт уншиж гүйцэтгэх 10 даалгаврын 8 даалгавар нь хүнд, хүндэвтэр даалгаварт багтсан ялгах чадвар муутай даалгавар байсан нь тестэд хийсэн анализэд гарсан. Иймээс ахлах ангийн сурагчдыг эхтэй ажиллуулахдаа:

- Зорилготой унших арга барилд сургах
- Гол түлхүүр санааг олох, таамаглуулах чадвар олгох
- Түлхүүр өгүүлбэрт тулгуурлан гол ба туслах санааг тодорхойлох
- Хам сэдвийн хүрээнд үгийн утгыг таамаглуулах
- Үгийн олон утгыг ялган таних арга эзэмшүүлэх
- Үйл явдлын учир шалтгааныг олох замаар унших ойлгоход чадварт суралцуулах аргыг хичээл сургалтадаа түлхүү хэрэглэхийг зөвлөж байна.

“Уншлагыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд англи хэл дээр сурагчдын нас бие сэтгэхүйн онцлогт тохирсон богино хэмжээний эх, хялбаршуулсан ном зохиолыг уншуулж тэмдэглэл хөтлүүлэх, яриулах, хэлэлцүүлэг хийх замаар унших ойлгох чадварыг нэмэгдүүлэх нь зүйтэй.